

“Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн хүрээнд хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн чиглэлээр сургуульд суурилсан кампанит ажлыг зохион байгуулах, ажлыг гүйцэтгэх байгууллагыг сонгон шалгаруулах шалгаруулалтын өгөгдөл

Японы Хүүхдийг Ивээх Сан нь хүүхэд бүр эсэн мэнд амьдрах, хамгаалуулах, хөгжих, оролцох эрхээ эдэлдэг ертөнцийг бий болгох алсын хараатай, хүүхдэд эерэг нөлөө үзүүлж, тэдний амьдралд урт хугацааны өөрчлөлт авчрах эрхэм зорилготой хүүхдийн төлөөх ажил үйлсээрээ тэргүүлэгч, шашин, улс төрөөс ангид олон улсын бие даасан байгууллага бөгөөд олон улсад 1919 оноос, Монгол улсад 1994 оноос хойш үйл ажиллагаа явуулж, боловсрол, эрүүл мэнд, хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн засаглал болон хүмүүнлэгийн яаралтай тусламж үзүүлэх чиглэлээр ажиллаж байна.

Та бүхэн Хүүхдийг Ивээх Сангийн үйл ажиллагаа, бидний хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрүүд, манай байгууллагын бодлого журмын талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл <https://www.savethechildren.mn/> хаягаар орж танилцаарай.

Японы Хүүхдийг Ивээх Сан нь “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн хүрээнд хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн чиглэлээр сургуульд суурилсан кампанит ажлыг зохион байгуулах, ажлыг гүйцэтгэх өндөр үр чадвар, туршлага бүхий байгууллагыг сонгон шалгаруулна.

БҮЛЭГ 1. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДӨЛ

№	1. Ерөнхий зүйл
1	Захиалагч нь: Японы Хүүхдийг Ивээх Сан (ХИС)
2	Сонгон шалгаруулалтын нэр: “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн хүрээнд хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн чиглэлээр сургуульд суурилсан кампанит ажлыг зохион байгуулах, ажлыг гүйцэтгэх байгууллагыг сонгон шалгаруулах. Сонгон шалгаруулалтын дугаар: SCJT-01/2024. Сонгон шалгаруулалтын багцын талаарх мэдээлэл: Багцгүй
3	Санхүүжилтийн эх үүсвэр нь: Японы Хүүхдийг Ивээх Сан, ХИС-ийн Олон Улсын Эвсэл
4	Санал хүлээн авах захиалагчийн хаяг: Японы Хүүхдийг Ивээх сан, Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Аризона төв, 4-р давхар Лавлах утас: 976-11-329365-120,121 Сонгон шалгаруулалтыг ялгаж, таних зорилгоор саналын гаднах дугтуйд дараах нэр, ялгах дугаарыг гаргацтай тэмдэглэнэ. Сонгон шалгаруулалтад оролцогч нэр хаяг, утсаа тодорхой бичнэ. Техникийн санал болон Санхүүгийн саналыг хамтад нь нэг дугтуйнд хийн битүүмжилж, “ ТЕХНИК болон САНХҮҮГИЙН САНАЛ ” гэж тэмдэглэн битүүмжилж дээрх хаяг болон бусад мэдээллийг бичиж, тэмдэглэнэ.
5	Санал хүлээн авах эцсийн хугацаа: Огноо: 2024 оны 3 дугаар сарын 20-ны өдөр Цаг: 17 цаг 00 минутаас өмнө битүүмжилсэн хэлбэрээр ирүүлэх
2. ТЕХНИКИЙН САНАЛЫН БИЧИГ БАРИМТ	
1	Техникийн дэлгэрэнгүй санал (ажлын төлөвлөгөө, арга зүй, удирдлага зохион байгуулалт зэргийг багтаасан) (Маягт 1) ирүүлнэ.
2	Кампанит ажлыг зохион байгуулах удирдах болон голлох боловсон хүчний чадвар, туршлагын талаарх мэдээлэл: Шаардана. Тус нөлөөллийн ажлыг хийж гүйцэтгэхэд санал болгож буй хүний нөөцийн мэдээлэл (Маягт 2), кампанит ажлыг удирдах болон голлох мэргэжлийн ажилтнууд, зөвлөхүүдийн CV/ намтрыг (Маягт 3) сургууль төгссөн дипломын хуулбарын хамт ирүүлнэ.
3	Сонгон шалгаруулалтад баталгаа ирүүлэх эсэх: Шаардахгүй.
4	Улсын бүртгэлийн гэрчилгээ: Шаардана.

5	Хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажлын жагсаалт: Шаардана. Сүүлийн 2 жил хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажлын жагсаалтыг гэрээ, гэрээ дүгнэсэн акт, тодорхойлолт гэх мэт нотлох баримтын хамт ирүүлнэ. Үүнд одоо хийж байгаа болон хийхээр төлөвлөсөн, гэрээ байгуулах эрх авсан ажил багтаж болно. (Маягт 4) .
3. САНХҮҮГИЙН САНАЛЫН БАРИМТ БИЧИГ	
1	Санхүүгийн саналын хэл: Монгол
2	Санхүүгийн тайлан: Шаардана. 2023 оны аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан.
3	Бусад тайлан: Шаардана. 2024 оны 01 -р сарын баталгаажсан НДШ-ийн тайлан.
4	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт: Шаардана. Сонгон шалгаруулалтын материал хүлээн авах эцсийн өдрөөс ажлын 3 хоногийн өмнө авсан байх
5	Дотоодын давуу эрхийн зөрүү: Тооцохгүй
6	Гадаадын этгээд оролцох эсэх: Эрхгүй
7	Хувилбарт үнийн санал ирүүлэхийг зөвшөөрөх эсэх: Зөвшөөрөхгүй
8	Санхүүгийн саналын иж бүрдэл: Сонгон шалгаруулалтад оролцогч нь Санхүүгийн санал (Маягт 5) , санал болгож буй Төсвийн хураангуй (Маягт 6) , Төсвийн дэлгэрэнгүй задаргаа (Маягт 7) -г ирүүлнэ.
9	Татвар хураамж: Кампанит ажлыг гүйцэтгэхтэй холбоотой гарах татвар, хураамж, шимтгэлийг санал болгож буй үнэд багтаан ирүүлнэ.
10	Үнийн саналын хүчинтэй байх хугацаа нь: Үнийн саналыг нээснээс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
11	Үнийн саналын эх хувиас гадна ирүүлэх хуулбар хувь: Шаардлагагүй. Сонгон шалгаруулалтад оролцогч материалыг өөрийн биеэр эсвэл бие төлөөлөгчөөр захиалагчид хүргүүлнэ. Зөвхөн ЭХ ХУВЬ битүүмжилсэн материалыг хүлээн авна.
2. Үнийн саналын баримт бичиг	
1	Захиалагчаас үнийн саналын баримт бичигтэй холбоотой тодруулга авах хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Аризона төв, 4-р давхар, Захиргаа худалдан авалтын хэлтэс Утас: 976-11-329365-120,121 И-мэйл хаяг: mongolia.procurement@savethechildren.org
2	Үнийн санал ирүүлэхийн өмнөх үүлзэлт зохион байгуулах эсэх: Үгүй.
4. Үнийн санал ирүүлэх	
1	Үнийн санал хүлээн авах захиалагчийн хаяг: Японы Хүүхдийг Ивээх Сангийн төв оффис, Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 1-р хороо, Аризона төв, 4-р давхар Лавлах утас: 976-11-329365-120, 121
2	Сонгон шалгаруулалтыг ялгаж, таних зорилгоор үнийн саналын гаднах дугтуйд дараах нэр, ялгах дугаарыг гаргацтай тэмдэглэнэ: Сонгон шалгаруулалтын нэр: “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн хүрээнд хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн чиглэлээр сургуульд суурилсан кампанит ажлыг зохион байгуулах, ажлыг гүйцэтгэх байгууллагыг сонгон шалгаруулах Сонгон шалгаруулалтын дугаар: SCJT-01/2024. Сонгон шалгаруулалтад оролцогч нэр хаяг, утсаа тодорхой гаргацтай бичнэ.
3	Үнийн санал хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: 2024 оны 3 дугаар сарын 20-ны өдөр Цаг: 17 цаг 00 минутаас өмнө битүүмжилсэн хэлбэрээр ирүүлэх
5. Техникийн болон Үнийн саналыг нээх	
Санал ирүүлэх эцсийн хугацаа дуусмагц үнэлгээний баг Техникийн санал, Санхүүгийн саналыг нээнэ. Үнэлгээний баг ажлын удирдамжид заасан шаардлагад үндэслэн сонгон шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтэд заасан үнэлгээний шалгуур, онооны системийг ашиглаж үнэлгээг хийнэ. Саналд үнэлгээний багийн гишүүн тус бүр оноо өгч, оноог нэгтгэн дундаж оноог гаргана. Энэ шатанд техникийн даалгаврын үндсэн нөхцөл, эсхүл Тендерийн өгөгдлийн хүснэгтэд заасан техникийн доод оноог хангаагүй тохиолдолд тендерээс татгалзана	

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1	<p>Гэрээнд гарын үсэг зурах: Гүйцэтгэгчээр шалгарсан оролцогч нь гэрээ байгуулах тухай мэдэгдсэнээс хойш ажлын 5-аас доошгүй хоногийн дараа, үнийн саналын хүчинтэй байх хугацаанд багтаж гэрээг байгуулна.</p> <p>Ажил эхлэх өдөр: Гэрээ байгуулсан өдөр.</p> <p>Баталгаат хугацаа: Ажлын удирдамжид заасан.</p> <p>Татвар, даатгал хураамж: Ажил гүйцэтгэхтэй холбоотой бүх төрлийн татвар, даатгал, хураамжийг хүүлийн дагуу суутгана.</p> <p>Захиалагчийн төлөх алдангийн хувь: Хоног тутамд 0.2 хувь.</p> <p>Гүйцэтгэгчийн төлөх алдангийн хувь: Хоног тутамд 0.2 хувь</p> <p>Төлбөрийн нөхцөл: Ажлын удирдамжид заасан хуваарь, сар болгоны сургалтын хуваарийн дагуу 100 хувь гүйцэтгэл дээр суурилан төлбөр хийгдэнэ.</p> <p>Төлбөр хийх хугацаа: Төлбөрийн мэдэгдэл гаргасан өдрөөс хойш 7 өдөрт багтаан санхүүжилтийг хийнэ.</p> <p>Гүйцэтгэлийн тайлан: Санхүүжилтийн хуваарийн дагуу хүлээн авна</p> <p>Гэрээний үнэ: Гэрээний үнэд тохируулга хийхгүй гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байна.</p>
---	---

БҮЛЭГ 2. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ/АЖЛЫН УДИРДАМЖ
“СУРГУУЛЬТАЙ ХАМТРАН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫГ САЙЖРУУЛАХ НЬ” ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХҮҮХЭД
ХАМГААЛАЛ, ХҮҮХДИЙН ЭРХИЙН ЧИГЛЭЛЭЭР СУРГУУЛЬД СУУРИЛСАН НӨЛӨӨЛЛИЙН АЖЛЫГ ЗОХИОН
БАЙГУУЛАХ АЖЛЫН

1. ТАНИЛЦУУЛГА

1.1 Хүүхдийг Ивээх Сан ба “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төсөл

Хүүхдийг Ивээх Сан (ХИС) нь хүүхдийн төлөөх үйлсээрээ дэлхийд тэргүүлэгчдийн нэг, шашин, улс төрөөс ангид, олон улсын, бие даасан төрийн бус байгууллага юм. ХИС нь дэлхийн 120 улсад хүмүүнлэгийн болон хөгжлийн чиглэлийн үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд Монгол Улсад 1994 оноос ажиллаж байна. Монгол Улс дахь ХИС нь Хүүхэд хамгаалал, Хүүхдийн Эрхийн Засаглал, Боловсрол, Хүүхдийн Ядуурлыг Бууруулах, Эрүүл мэнд, Хүмүүнлэгийн тусламжийн үндсэн чиглэлүүдийн дагуу ажилладаг. (Дэлгэрэнгүй мэдээллийг дараах цахим хуудаснаас авна уу.

(<https://www.savethechildren.mn/index.php/>)

ХИС нь Хүүхэд хамгааллын хөтөлбөрийнхөө хүрээнд ХИС-гийн Олон Улсын Эвслийн санхүүжилттэйгээр сургуулийн багш ажилтнууд, эцэг эх/асран хамгаалагчид, сурагчид болон Хамтарсан багуудыг хамруулан сургуульд суурилсан хүүхэд хамгааллын механизмыг хөгжүүлэх, улмаар үр дүнтэй урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, хариу арга хэмжээ авах хамтын ажиллагааны загварыг бий болгох зорилтын хүрээнд “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийг 2023-2025 онд хэрэгжүүлж байна.

Энэхүү төсөл нь Улаанбаатар хотын Чингэлтэй, Баянгол, Хан-Уул, Сүхбаатар, Баянзүрх дүүрэг, Говь-Алтай, Ховд аймгуудын нийт 14 сургуулиудад хэрэгжиж байгаа бөгөөд төслөөр багш, сургуулийн ажилтнууд, эцэг эхчүүдийг сурагчдын сурч, хөгжих үйл явцыг хүчирхийллийн бус аргаар чиглүүлэх, дэмжин чадавхжуулах, улмаар хамтарсан багуудтай хүүхэд хамгаалалд хамтран ажиллах практик, арга зүйгээр дэмжих, хүүхдийн оролцоог хөгжүүлэх замаар тэдэнд тулгарч болзошгүй бэрхшээлийг даван туулах, үе тэнгийнхэндээ зөвлөн туслах үр чадварыг эзэмшүүлэх юм.

1.2 Сургуульд суурилсан кампанит ажил

ХИС нь “Сургуультай хамтран хүүхэд хамгааллыг сайжруулах нь” төслийн хүрээнд хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн чиглэлээр сургуульд суурилсан кампанит ажлыг зохион байгуулах, ажлыг гүйцэтгэх өндөр үр чадвар, туршлага бүхий байгууллагыг сонгон шалгаруулна.

Үндэслэл

Монгол Улс нь хүүхдийг нийгмийн бүх орчинд хүчирхийлэл, дарамт мөлжлөг, үл хайхрах байдлаас ангид байлгах, тэдний хамгаалагдах эрхийг хуулиар баталгаажуулах бодлого хэрэгжүүлснээр хүүхдийн эсрэг хүчирхийллийг бүх орчинд хориглосон дэлхийн 491 дэх орон болсон. Мөн, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 5.2-т хүүхэд эрүүл өсөж бойжих, аюулгүй орчинд амьдрах, аливаа хүчирхийллээс ангид байх эрхтэй гэж заасан байдаг билээ. Гэсэн хэдий ч, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчил жилээс жилд өссөн үзүүлэлттэй байна. Сүүлийн 5 жилийн байдлаар хүүхдийн эсрэг үйлдэгдэж байгаа гэмт хэргийн тоон судалгааны хувьд 2018 онд нийт гэмт хэргийн улмаас 1,688 хүүхэд хохирсон, 2019 онд 1,598 хүүхэд хохирсон бол Ковидын буюу цар тахлын үеүдэд 1,181 болон 1,365 болтлоо буурсан. Гэсэн ч, 2022 онд хүүхдийн эсрэг 2,014 гэмт хэрэг бүртгэгдсэн байна. 2023 оны эхний хагас жилийн байдлаар цагдаагийн байгууллагын хэмжээнд хүүхдийн эсрэг үйлдэгдсэн 960 гэмт хэрэгт 990 хүүхэд хохирсон гэсэн үзүүлэлттэй байна².

Түүнчлэн сургуулийн орчин дахь үе тэнгийн дээрэлхэл жилээс жилд нэмэгдэх хандлага ажиглагдсаар байна. Улаанбаатарын есөн дүүрэг болон найман аймагт амьдарч буй 12-18 насны нийт 4,264 хүүхдийг үе тэнгийн дээрэлхэлтэй холбоотой судалгаанд 2017 онд хамруулжээ. Тэдний 82.8 хувь нь үе тэнгийн дээрэлхэл, хүчирхийлэлд өртөж байсан хэмээн хариулсан байна. Тухайлбал, үг хэлээр доромжлох 62 хувь, чимхэх 50.2 хувь, цохиж зодох 43.5 хувь, үл хайхрах 27.8 хувь тус тус үзүүлэлттэй гарчээ. Сургуулийн орчинд

¹ Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр, МУ-ын Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолын хавсралт

² <https://www.uih.mn/ns/view/110>. Хүүхдийн эрхийн зөрчлийн талаарх тоо баримт

хүүхдийн эрхийг зөрчиж, хүчирхийлэл үйлдэгч гол этгээд нь дээд ангийн хүүхэд 47.6 хувь, багш 15 хувь гэж хариулсан байна³. Түүнчлэн 2023 онд хийгдсэн “Боловсролын орчин дахь хүүхдийн эрүүл мэнд, зан үйлийн судалгаа-2023”-д онцолсноор хүүхдийн эрхийг хамгийн их зөрчдөг хүмүүсээр үе тэнгийн хүүхдүүд нэрлэгдсэн бөгөөд өсвөр үеийнхний 37.4 хувь нь энэ хариултыг өгсөн байна.

Анги болон сургуульдаа сэтгэл зовоосон асуудлаа бусадтай хуваалцах боломж ихэнхдээ байсан гэж 5 суралцагч тутмын 1, боломж огт байгаагүй гэж 5 суралцагч тутмын 3 хариулжээ. Эцэг эх, асран хамгаалагчийн хувьд тэдний сэтгэл зовоосон асуудлыг ойлгож, дэмждэг гэж 5 суралцагч тутмын 1 нь, огт ойлгож дэмждэггүй гэж 5 суралцагч тутмын 3, гэрийн даалгавар хийсэн эсэхийг байнга шалгадаг гэж 5 суралцагч тутмын 1, огт шалгадаггүй гэж 5 суралцагч тутмын 3, чөлөөт цагаа өнгөрөөх байдалд анхаардаг гэж 5 суралцагч тутмын 3, анхаардаггүй гэж 3 суралцагч тутмын 1 нь хариулсан байна. Эцэг эх, асран хамгаалагч нарын харилцаа, хандлагын талаар судлахад 5 суралцагч тутмын 3 нь дооглож, тохуурхан, доромжилсон гэж хариулсан байна⁴.

Иймд хүүхдийн эсрэг хүчирхийлэл, үе тэнгийн хүчирхийллийн талаар хүүхэд болон багш, сургуулийн ажилтнууд, эцэг эх, асран хамгаалагч, үйлчилгээ үзүүлэгчдэд зөв мэдлэг мэдээллийг өгөх, тэдний хандлага, дадлыг өөрчлөх шаардлага урган гарч байна.

Зорилго

Бид энэ кампанит ажлыг сургуулийн сурагчдад зайлшгүй эзэмшүүлсэн байх ёс зүй, үнэт зүйлсийн хүрээнд хүүхдүүд, багш, эцэг эхийн идэвхтэй оролцоо, хамтын ажиллагаа дэмжлэгтэйгээр зохион байгуулахыг зорьж байна. Төслийн зорилтот 14 сургуулийн бага (1-5), дунд (6-9), ахлах (10-12) анги гэсэн гурван түвшинд сургуульд суурилсан болон цахим хувилбаруудаар хэрэгжүүлнэ. Ингэхдээ хүүхдүүдийн насны 3 бүлгийн онцлогт тохирсон, хүүхдэд зориулагдсан байдлаар контентуудыг боловсруулах, тэднийг оролцуулах, мөн энэ нөлөөллийн ажлыг багш, эцэг эх нь зөв ойлгож, зэрэгцэн дэмжих даалгавар аргачлалтайгаар зохион байгуулахад анхаарах юм.

Хамрах хүрээ

Шууд:

- Төслийн зорилтот 14 сургуулийн багаас ахлах ангийн нийт 33,016 сурагчид,
- Төслийн зорилтот 14 сургуулийн нийт 1,800 багш, ажилтнууд,
- Төслийн зорилтот 14 сургуулийн нийт 70,000 эцэг, эхчүүд

Шууд бус:

Монгол Улсын ерөнхий боловсролын сургуулийн нийт 771,7225 сурагчид

Хамрах хугацаа

2024 оны 3-12 сарууд байна.

2. ГҮЙЦЭТГЭГЧ ТАЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА, АЖИЛ ҮҮРГИЙН ЖАГСААЛТ

2.1. Хийх ажлын жагсаалт

1. Ажлын нарийвчилсан төлөвлөгөөг багтаасан Эхлэлийн тайланг монгол, англи хэлээр төслийн багт илгээх;
2. Төлөвлөгөөний дагуу контент боловсруулах;
3. Төлөвлөгөөний дагуу нөлөөллийн ажлыг зохион байгуулах;

³ “Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн зарим асуудал” судалгаа. 2017 он. ХЭҮК

⁴ “Боловсролын орчин дахь хүүхдийн эрүүл мэнд, зан үйлийн судалгаа-2023”

⁵ БШУЯ, Монгол Улсын ЕБС-ын 2023-2024 оны нийт сурагчдын тоо

4. 2 долоо хоног тутам явцын тайланг монгол хэлээр төслийн багт илгээх;
5. Нөлөөллийн ажлын эцсийн тайланг монгол, англи хэлээр төслийн багт илгээх
6. Нөлөөллийн ажлын судалгааг хийх хөндлөнгийн судалгааны байгууллагатай хамтран ажиллах, шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах

2.2. Тавигдах үндсэн шаардлага, хэрэгжүүлэх цаг хугацаа

№	Нөлөөллийн ажлын үе шат	Тавигдах үндсэн шаардлага	Хугацаа /гэрээнд гарын үсэг зурснаас хойш/
1	Эхлэлийн тайлан	<ul style="list-style-type: none"> - Нөлөөллийн ажлын гарааны судалгааг хийх хөндлөнгийн судалгааны байгууллагатай хамтран ажиллах, шаардлагатай мэдээллээр хангах - Төслийн багаас ирүүлсэн санал болон гарааны судалгааны үр дүнд тулгуурлан, нөлөөллийн ажлын нарийвчилсан төлөвлөгөөг эцэслэн төслийн багаар батлуулах - Төлөвлөгөө нь нөлөөллийн үйл ажиллагааны хүрээнд зохион байгуулагдах үйл ажиллагааны жагсаалт, боловсруулах контентын тоо, суваг, цацалтын тоо, давтамж, цаг хугацаа, хүлээн авагчийн тоо, шалгуур үзүүлэлт, үр дүн гэх мэтийг аль болох нарийвчлалтайгаар багтаасан байна. 	2024 оны 3-4 сарууд
2	Контент боловсруулалт	<ul style="list-style-type: none"> • Нөлөөллийн ажлын хүрээнд дараах төрлүүдээр нийт 100 болон түүнээс дээш бүрэн контентыг боловсруулна. Үүнд: Тик ток, рийл, YouTube shorts, субтитртэй, дохионы хөрвүүлэгтэй видео, аудио, багц нэр бүхий лого, ковер, сошиал медиа фрэйм, постер, хөдөлгөөнт зураг, видео (дүрд тоглосон болон анимэйшн, сошиал нөлөөлөгчдийн пост, сургуульд суурилсан эцэг эх багш сурагчдын идэвхжүүлэлтийн арга хэмжээ, амжилтын түүхүүдийг хамарсан байна. • Бусад (Захиалагчийн зүгээс боломжтой гэж үзсэн үйлчилгээ үзүүлэгчийн зүгээс санал болгосон төслийн зорилгод нийцэхүйц өөр бусад арга хэмжээ) • Төлөвлөгөөний дагуу контентын агуулга, санаа, зохиолыг төслийн багтай хэлэлцэн боловсруулж, батлуулах. • Боловсруулсан контент нь хүүхдийн эрхийг зөрчихгүй байх, тэгш, хүртээмжтэй аргачлалаар бүтээгдсэн байх, • Хүүхэд оролцуулах тохиолдолд тухайн хүүхэд, түүний гэр бүлээс зөвшөөрөл авч зөвшөөрлийн хуудсанд гарын үсэг зуруулах. 	2024 оны 4-8 сарууд
4	Нөлөөллийн ажлын хэрэгжилт	<ul style="list-style-type: none"> - Боловсруулсан контентыг олон нийтийн сүлжээгээр цацах нарийвчилсан төлөвлөгөө боловсруулах. Ингэхдээ, 2024 оны 4-5 саруудад боловсруулалт хийсэн эхний контентуудыг 2024 оны 5-6 саруудад цацалт хийхээр төлөвлөгөөндөө тусгах. Өөрөөр хэлбэл 2024 оны 4-6 саруудад контентуудын боловсруулалт болон цацалт нь зэрэгцээ байдлаар явахад анхаарах. 	2024 оны 4-6 ба 9-12 сарууд

		<ul style="list-style-type: none"> - Төлөвлөгөөнд тусгагдсан бүх үйл ажиллагааг чанарын өндөр түвшинд гүйцэтгэн, төлөвлөгөөний дагуу цацах, бүүст хийх. - 2 долоо хоног тутмын тайланд үйл ажиллагааны хэрэгжилтийн явц болон нийт хүрсэн хүний тоог Төслийн баг болон судалгаа хийж байгаа хөндлөнгийн судалгааны байгууллагад илгээх, шаардсан мэдээллээр цаг тухайд нь хангах 	
5	Хяналт /Төслийн багийн хамт/	<ul style="list-style-type: none"> - Контент бүрийн доор зорилтот бүлгийн өгч буй комментыг хянах, шаардлагатай тохиолдолд төслийн багт мэдээлэх, дамжуулах (тусламж хүссэн, мэдээлсэн, хариу арга хэмжээ авах шаардлагатай гэх мэт) - ХИС-гийн Хүүхэд хамгааллын протокол, ёс зүйн дүрэм, Хүүхдийн оролцооны стандартыг мөрдөж буй эсэхэд хяналт тавьж, зөвлөнө. 	Хэрэгжилтийн явцад
6	Тайлагналт	<ul style="list-style-type: none"> - Нөлөөллийн ажлын үр дүнг хэмжих эцсийн судалгааг хийхэд хөндлөнгийн судалгааны багт дэмжлэг үзүүлж ажиллах, шаардлагатай мэдээ мэдээллээр хангах - Судалгааны явцад кампанит ажлын үр дүнг харуулсан Амжилтын түүхүүдийг боловсруулна. Эдгээр нь нөлөөллийн ажлын үр дүнд бий болсон үйл хөдлөл, зан төлөвийн өөрчлөлтийг тусгасан байж болно. - Нөлөөллийн ажлын үр дүнг ХИС-д танилцуулна. - Нөлөөллийн ажлын Эцсийн тайланг англи, монгол хэл дээр Төслийн багт хүлээлгэн өгнө. 	2024 оны 12-р сарын 2 дахь долоо хоног

2.3. Гүйцэтгэгч талд тавигдах шаардлага

- Нөлөөллийн ажлын зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх удирдлага, менежмент, хүний нөөц, техникийн чадамжтай байх
- Тодорхой үр дүнд хүрсэн уламжлалт болон сошиал медиа нөлөөллийн ажил өмнө нь хийж байсан туршлагатай байх (олон улсын байгууллагуудтай ажиллаж байсан бол давуу тал болно)
- Шинэ тренд, орчин үеийн хэв маягийг контент боловсруулалтдаа тусгадаг байх
- Захиалагчаас ирүүлсэн санал хүсэлт, засварыг цаг тухайд нь гүйцэтгэх хурд, чадвартай байх
- Нөлөөллийн ажлын туршид жендерийн мэдрэмжтэй, хүний эрхийг дээдэлсэн зарчмыг баримталж ажиллах
- Эрсдэлийг тооцоолон хариу арга хэмжээ авах чадвартай байх

2.4. Гүйцэтгэгч багийн бүрэлдэхүүн

а. Багийн ахлагч

Багийн ахлагчийн үүрэг:

- Чанартай сошиал нөлөөллийн ажил зохион байгуулах үүрэг хариуцлагыг хүлээх, хянаж эцэслэсэн боловсруулсан хувилбар захиалагчид ирүүлэх /гэрээний заасан хугацаанд ажлыг чанартай гүйцэтгэх/
- Төслийн багтай мэдээлэл солилцох, холбоо харилцааны ажлыг хариуцаж, зохицуулах
- Багийн гишүүдээ ерөнхий удирдлагаар хангах, ажлаа төлөвлөх, үүрэг өгөх, дэмжин туслах
- Ажлын явц, үйл ажиллагааны талаар гэрээнд заагдсан хугацаанд Захиалагчид тогтмол тайлагнах

Багийн ахлагчид тавигдах шаардлага:

- Сэтгүүл зүй, олон нийттэй харилцах, маркетинг, мэдээлэл харилцаа холбооны чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй байх
- Тухайн салбартаа 10-аас багагүй жил ажилласан байх, тэр дундаа 5 жилд нь удирдах, баг манлайлах үүрэг гүйцэтгэсэн бол давуу тал болно.

- Нийгмийн чиглэлийн нөлөөллийн ажил удирдан, зохион байгуулж туршлагатай бол давуу тал болно.
 - Олон улсын байгууллага, төсөл хөтөлбөртэй хамтарч ажиллаж байсан давуу тал болно.
 - Төслийн менежмент, төлөвлөлт ба гүйцэтгэл амжилттай хэрэгжүүлсэн туршлагатай байх
- b. Зохиолч/сэтгүүлч (хүүхдийн тархины хөгжил, хүмүүжил, хөгжлийн хэрэгцээ шаардлагыг судалж, хүүхдийн чиглэлээр бүтээл хийж байсан бол давуу тал болно)
- c. Найруулагч, зураглаач, зурагчин
- d. Хүний эрхийн, хүүхэд хамгааллын чиглэлийн зөвлөх
- e. Сурган хүмүүжүүлэх, тархи судлал, заах аргын зөвлөх

Жич: Багийн гишүүд зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй.

3. БУСАД

3.1. Төслийн багийн оролцоо

Төслийн баг судалгаа хийхэд шаардлагатай зарим зөвшөөрлийг холбогдох төрийн байгууллагаас авахад дэмжлэг туслалцаа үзүүлж, контентын утга агуулга ХИС-гийн дүрэм, стандартад нийцэж буй эсэхэд зөвлөмж өгч ажиллана. Мөн сонгон шалгаруулалтад нийцсэн байгууллагад зохион байгуулах ажлын даалгаврын дэлгэрэнгүйг агуулга ба сэдвийн хүрээнд өгнө.

3.2. Төлбөр хийх хугацаа

Д/д	Хийгдэх ажлууд	Шилжүүлэх хувь
1	Нөлөөллийн ажлын төлөвлөгөөг багтаасан Эхлэлийн тайланг эцсийн байдлаар англи, монгол хэлээр илгээх	40%
4	Төлөвлөгөөний дагуу контент боловсруулах, Захиалагчаар батлуулах	30%
5	Нөлөөллийн ажлын Эцсийн тайлангийн анхны хувилбарыг монгол хэлээр илгээх	20%
6	Төслийн багийн санал зөвлөмжийн дагуу сайжруулсан Эцсийн тайланг эцэслэн англи, монгол хэлээр илгээх	10%

САНАЛ БОЛГОЖ БУЙ ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭДЭЭЛЭЛ

№	Албан тушаал	Ажилтны нэр	Боловсрол, мэргэжлийн үр чадвар	Нийт ажлын туршлага /жилээр/	Санал болгож буй албан тушаалтай ижил албан тушаалд ажилласан туршлага /жилээр/

САНАЛ БОЛГОЖ БУЙ ХҮНИЙ НӨӨЦ, ЗӨВЛӨХИЙН CV/НАМТАР
(Уг зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх хүн тус бүрээр бөглөнө.)

1	Ажиллах албан тушаал:	Ажлын удирдамжид заасан албан тушаал
2	Байгууллагын нэр:	Одоо ажиллаж байгаа байгууллага
3	Ажилтан/зөвлөхийн нэр:	
4	Гэрийн хаяг:	
	Утасны дугаар:	
	Мэйл хаяг:	
5	Төрсөн огноо:	
6	Боловсрол:	Төгссөн сургууль, огноо, эзэмшсэн эрдмийн цол, хэргэм,
7	Мэргэжлийн байгууллагын гишүүнчлэл:	
8	Хамрагдаж байсан сургалт:	1-д бичигдсэн албан тушаалтай хамаарал бүхий хамрагдаж байсан сургалт
9	Олон улсад ажиллаж байсан туршлага:	Улс: Эхэлсэн (сар/жил): Дууссан (сар/жил): Байгууллага: Албан тушаал:
10	Гадаад хэл:	
11	Ажлын туршлага:	Эхэлсэн (сар/жил): Дууссан (сар/жил): Байгууллага: Албан тушаал:
12	Хийж гүйцэтгэх ажил үүрэг: (1-д заасан ажлыг хийж гүйцэтгэхэд хүлээх үүрэг)	
13	Өгөгдсөн үүрэг даалгаврыг хийж гүйцэтгэх чадварыг харуулсан ажлын туршлага (12-д заасан ажил үүргийг хийж гүйцэтгэхэд шаардагдах үр чадварыг харуулсан ажлын туршлага)	Ажил/төслийн нэр: Жил, сар: Захиалагч: Төслийн товч мэдээлэл: Албан тушаал: Голлох үүрэг:

Батламж:

Дээр өгсөн мэдээлэл нь үнэн зөв гэдгийг би үүгээр гарын үсэг зуран баталж байна:
Энэхүү CV/намтар нь миний үр чадвар, туршлагыг зөв тодорхойлсон;

Эрүүл мэндийн байдал гэх мэт хүндэтгэх шалтгаануудаас бусад нөхцөлд би энэхүү зөвлөх үйлчилгээг хэрэгжих хугацаанд надад оногдсон үүрэг хариуцлагын хүрээнд энэ даалгаврыг бүрэн дүүрэн хийж гүйцэтгэх болно;

Энэхүү тендерийн саналд миний CV/намтрыг оруулсан талаар тус байгууллага надад мэдэгдсэн бөгөөд зөвлөх үйлчилгээг хэрэгжих хугацаанд заасан хуваарийн дагуу би өөрт ноогдсон үүрэг даалгавраа биелүүлэх болно;

Би хүүхэд хамгааллын ямар нэг зөрчил, ёс зүйн асуудал гаргаж байгаагүй.

МАЯГТ 4

СҮҮЛИЙН 2 ЖИЛ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН ИЖИЛ ТӨСТЭЙ АЖЛЫН ЖАГСААЛТ

№	Төсөл/Гэрээний нэр	Захиалагч байгууллагын нэр, хаяг, холбоо барих утас	Гүйцэтгэсэн хугацаа (дууссан, эсхүл дуусах хугацаа)	Гэрээний үнэ (сая.төг)	Онлайн орчинд байгаа линк

САНХҮҮГИЙН САНАЛ

[огноо]

[Захиалагч байгууллагын нэр]-д

Манай [оролцогчийн нэр] нь танай байгууллагаас зарласан [зөвлөх үйлчилгээний нэр, дугаар] сонгон шалгаруулалтад [санхүүгийн үнийн дүнг тоогоор болон үсгээр бичнэ] төгрөгөөр сонгон шалгаруулалтын баримт бичигт заасан хуваарийн дагуу зөвлөх үйлчилгээний ажил гүйцэтгэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү үнийн санал (цаашид “**үнийн санал**” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Сонгон шалгаруулалтын бичиг баримттай танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч сонгон шалгаруулалтад оролцсон.
2. Үнийн саналтай холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
3. Үнийн санал нь сонгон шалгаруулалтын баримт бичигт заасны дагуу үнийн саналыг нээснээс хойш **[30 ба түүнээс дээш хоногийн тоо]** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
4. Үнийн саналд хуурамч баримт бичиг, мэдээллийг хүргүүлсэн бол уг саналыг илт худал мэдээлэл бүхий санал гэж тооцохыг хүлээн зөвшөөрч байна.
5. Үнийн саналыг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, үнийн саналыг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэнчөлөөлж байна.

[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд, эсхүл түүнээс

эрх олгогдсон этгээдийн нэр, албан тушаал, гарын үсэг,

байгууллагын тамга, тэмдэг]:Хаяг:

ТӨСВИЙН ХУРААНГУЙ

Но.	Зардлын хураангуй	Төсөв (төгрөг)
1	Жишээ нь: Үйл ажиллагаа	
2	Цалин	
3	Захиргаа Удирдлага	
4	Цацалт	
5	Тоног төхөөрөмж	
6	
	Нийт	

ТӨСВИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ЗАДАРГАА

МАЯГТ 7

Но.	Зардлын утга	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ	Төсөв (төгрөг)
1	<i>Жишээ нь: Үйл ажиллагаа</i>				
1.1				
1.2				
1.3				
					Дүн
2	<i>Цалин</i>				
2.1				
2.2				
2.3				
					Дүн
3	<i>Захиргаа Удирдлага</i>				
3.1				
3.2				
3.3				
					Дүн
4	<i>Бусад</i>				
4.1				
4.2				
4.3				
					Дүн
5	<i>Тоног төхөөрөмж</i>				
5.1				
5.2				
5.3				
					Дүн
					НИЙТ